



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 595

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 38 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн ба нийслэлийн хөрөнгө оруулалтаар болон "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компанийн батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрээр бий болсон, нийт 790,970,000.00 (долоон зуун ерэн сая есөн зуун далан мянган) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газар түүний харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлэн авч арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны дугаар сарын 29-ны өдрийн
57 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Хьюндай каунти автобус, 08-62 УЕК, 28+1 суудалтай (арал-кмjhgi7bpnc500868)	2022	ш	1	240,000,000.00	240,000,000.00	Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагууд
2	Хьюндай каунти автобус, 08-61 УАР, 28+1 суудалтай (арал-кмjhgi7bpnc500599)	2023	ш	1	240,000,000.00	240,000,000.00	
3	Хьюндай старекс, 45-82 УЕЕ (арал-тjyud374bnu060277)	2024	ш	1	129,000,000.00	129,000,000.00	
4	Уаз-Хантер (арал-292409п1001185), дугааргүй	2021	ш	1	65,990,000.00	65,990,000.00	
5	УАЗ-220695-550 (арал-22069п1212752), дугааргүй	2021	ш	1	57,990,000.00	57,990,000.00	
6	УАЗ-220695-550 (арал-22069п1209209), дугааргүй	2021	ш	1	57,990,000.00	57,990,000.00	
	Нийт дүн					790,970,000.00	